

**“ЯДУУ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН
САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ”
ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ**

**ХЗХ-НЫ САЛБАРЫН ӨСӨЛТ, ТУЛГАМДАЖ
БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

1

Илтгэгч Ш.Гоохүү МХЗХҮХ-ны дарга

Хадгаламж, зээлийн хоршоо нь нийгэмд хоёр талын байр суурь эзэлсэн сонирхолтой бүтэц юм.

Нэгдэх нь бага дунд орлоготой, банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээг тэр бүр хүртээд байж чаддаггүй, тийм боломж хомсхонтой иргэдийн үүсгэл санаачлагаар байгуулагдаж өөрөө өөртөө үйлчилдэг бичил санхүүгийн байгууллагын хэлбэр.

Нөгөө нэг тал нь хоршооны үндсэн зарчмууд дээр тулгуурлан ажилладаг, хэнээс ч хараат бус биеэ даасан бүтэц юм.

1990-ээд оны дунд үеэс нийгмийн амьдралын зайлшгүй шаардлага, дэлхийд түгээмэл тархсан үлгэр загвар, чиг хандлага, гадаадын байгууллага, хүмүүсийн зөвлөмж, дэмжлэгийн ачаар манай улсад ХЗХ-ны хөдөлгөөн өрнөж эхэлсэн.

Манай улсын ХЗХ-ны хөдөлгөөний түүх харьцангуй богино билээ. Гэвч туулж өнгөрүүлээд байгаа энэ богинохон хугацаанд элдэв саад бэрхшээл тулгарч байсан. Түүнийг даван туулахад ихээхэн хүч хөдөлмөр зарцуулсан, одоо биеэ даасан хуультай болж, гадаадын ижил төстэй холбоод болон засгийн газрын төсөлд хамрагдсан ба хамрагдаж байгаа гээд сайн муу олон тохиолдлуудтай учирч ирсэн.

Бидний хөгжлийн замнал ийнхүү шулуун дардан байгаагүй боловч манай ихэнх хоршоологчид үнэн сэтгэлээрээ ажиллаж, ХЗХ-ны хөдөлгөөнийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэе, гишүүдийнхээ сайн сайхны төлөө зүтгье гэсэн зорилгодоо үнэнч хэвээр байсан тул монголын ХЗХ-ны хөдөлгөөн мухардмал байдалд ороогүй. Харин ч энэ хөдөлгөөн үүгээр цэвэршиж чадсан юм.

- 2005 онд “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” хууль гарч, ХЗХ-ны үйл ажиллагааг хянан зохицуулах үүрэгтэй төрийн бие даасан байгууллага болох “Санхүүгийн зохицуулах хороо”-г байгуулж, ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгодог болсон.
- Японы Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн хөрөнгийн эх үүсвэрээр АХБ-наас санхүүжүүлж байгаа “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн үр дүнд хадгаламж, зээлийн хоршоод монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа олон төрлийн хоршоодоос анх удаа өөрийгөө үнэлэх үнэлгээний системтэй болсон нь энэхүү төслийн хамгийн том үр өгөөжийн нэг юм.

Энэхүү системийн үндсэн зорилго нь “ХЗХ-дод үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын зүгээс ХЗХ-ны хэрэгцээнд нийцсэн дэмжих үйлчилгээ үзүүлэхийн тулд ХЗХ-ны чадавхийг үнэлэх, сургалт, чадахжуулалтын хэрэгцээг тодорхойлох” явдал байсан юм.

Үнэлгээний системийг ажлаа үнэлүүлж байгаа ХЗХ-дод ойлгомжтой, хэрэглэхэд хялбар, хэмжигдэхүйц үзүүлэлтүүдийг ашигласан байхаар бодож боловсруулсан чадавхийн үнэлгээ нь хяналт шалгалт биш, зөвөлгөө өгөх үйлчилгээг давхар гүйцэтгэдэг, хоршоод хоорондын хамтын ажиллагаа, харилцан бие биенээсээ суралцах боломж олгосон үйлчилгээний нэг хэлбэр.

Үнэлгээний системийг боловсруулж гаргах нь сайн хэрэг боловч үнэлгээ хийж, зөвөлгөө өгөх чадвартай үнэлгээчдийг бэлтгэх явдал бас л тулгамдсан асуудлын нэг байлаа. Энэ чухал асуудлыг бид төслийн хүрээнд амжилттай шийдвэрлэж, 2013 оны 2-р сард 29 хүнийг сургалтанд хамруулан бэлтгэсэн.

- Ингээд манай хоёр байгууллага (МХЗХҮХ, МХСМТ) бэлтгэж авсан үнэлгээчдийнхээ хүчээр 2012 оны 2-р сарын 20-аас 5-р сарын 10-ны хооронд нийт 118 хоршооны үйл ажиллагаанд газар дээр нь очин үнэлгээ хийж, зөвөлгөө өгсөн нь туршилтын үнэлгээ хийгдсэн 15 хоршоог оруулснаар тухайн үед үйл ажиллагаа явуулж байсан нийт хоршооны 89,9 хувийг хамруулж чадсан.
- Өнгөрсөн онд хийсэн үнэлгээ, зөвөлгөөнд хамрагдсан 118 хоршооны авсан онооны дүн бидэнд их зүйл хэлж өгсний дээр холбоо, хоршоо хоёрын хоорондын амьд холбоог бэхжүүлэх, бие биенээ илүү ихээр танин мэдэж хамтран ажиллахад ихээхэн түлхэц өгсөн.

Үнэлгээний нэгдсэн дүнгээс үзэхэд БГХ зэрэг хуулиар тогтоосон нарийн заалттай, СЗХ-ноос хяналт тавьдаг үзүүлэлтүүдийн гүйцэтгэл харьцангуй сайн байсан боловч санхүү, хөрөнгө мөнгөний болон хоршооны зарчимтай холбоотой ажлуудын гүйцэтгэл муу байсан нь анхаарал татаж, нэн даруй сайжруулах шаардлагатай эмзэг сэдэв болох нь тогтоогдсон.

Иймээс ч төслийн зөвлөхүүд “ХЗХ-ны зарчим, туршлагауд, Засаглал ба гишүүдийн оролцоо” гэсэн хоёр сэдэв дээр сургалтын 3 өдрийн (24 цагийн) модуль боловсруулж манай хоёр байгууллагын 24 хүнийг эдгээр сэдвийн сургагч багшийн 8 хоногийн сургалтанд хамруулан бэлтгэж өгснөөр бүх хадгаламж, зээлийн, хоршоодын 973 сонгуультнууд, гүйцэтгэх албаны хүмүүст газар дээр нь сургалт зохион байгуулж сертификатжуулсан.

Бидний энэ удаагийн сургалтын бас нэг онцлог нь хоршооны сургалтанд хоршооны дарга, эсвэл захирал, нягтлан бодогч зэрэг цөөн тооны хүмүүс л дахин давтан хамрагдаж байдгаас зайлсхийж, нэг ёсондоо мэдлэг, мэдээллийн төвлөрөл үүсдэг байсан гажуудлаас гарах арга замыг шийдвэрлэхэд доривтой ахиц гаргасан явдал юм.

Мэдлэг, мэдээллийн төвлөрөл нь тухайн хоршооны үйл ажиллагаа нэг, эсвэл цөөн хүнээс хэт хамааралтай болсноос тэр ганц хоёр хүн нь өөрчлөгдөх буюу ажил төрлөө биечлэн удирдах бололцоогүй болсон тохиолдолд уг хоршооны ажил эзэнгүйдэн доголддог эрсдэл үүсдэг байсныг бид халах цаг нь болсныг мэдэрсэн юм.

Иймээс үнэлгээний дараа хийгдсэн сургалтанд хоршооны тэргүүлэгчид, хяналтын зөвлөлийнхэн, гүйцэтгэх захирлуудийг 100 хувь хамруулахаар бодож нэг хоршооноос 10 хүртэл хүн оролцуулж байсан нь тэдний сэтгэл ханамжид илүү нийцсэн, өндөр ач холбогдолтой сургалт боллоо гэсэн үнэлгээг газар сайгүй өгч байлаа.

Үүнийг бид уг сургалтын үр дүн, ач холбогдлын урьдчилсан давуу тал хэмээн хүлээн авсан.

Өнгөрсөн онд баталсан үнэлгээний систем нь хөрөнгө, удирдлага, засаглалийн нийт 28 үзүүлэлтээр, 100 оноогоор дүгнэх систем байсан.

Үүнийгээ өнөө жил арай боловсронгуй болгон сайжруулж 32 үзүүлэлтээр, 135 оноогоор дүгнэсэн.

Бидний боловсруулан хэрэгжүүлж байгаа үнэлгээний энэ системийн үзүүлэлтээр авбал зохих онооны дээд туйл нь хүрвэл зохих хамгийн өндөр түвшин бол СЗХ-ноос батлан мөрдүүлж байгаа зохистой харьцааны үзүүлэлт нь хангасан байвал зохих шаардлагын доод түвшин юм.

Иймээс чававхийн үнэлгээний үзүүлэлтийг бүрэн дүүрэн хангаж байгаа хоршооны хувьд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ямар ч хүндрэлгүйгээр хангаад зогсохгүй дэлхийн түвшинд хүртлээ хөгжих боломжийг олж авах ач холбогдолтой юм.

Анхны үнэлгээгээр зайлшгүй анхаарвал зохих дор дурдсан асуудлууд гарч байлаа. Үүнд:

1. ХЗХ-ны амин чухал зүйл болсон зээлийн эх үүсвэр нь хадгаламжид суурилж байх зарчим манай олон хоршоодод сүрхий зөрчигдөж байгаа нь илэрсэн. Гишүүн бүр хадгаламжтай байх нь гишүүдийн үүрэг хариуцлага өндөрсөж, оролцоо нь дээшилдэг нийтлэг ач холбогдлын мөн чанарын үйлчлэл хангалтгүй байгааг засч залруулах шаардлага байна гэсэн дүнэлтэд хүрсэн;
2. Хоршоодын засаглалын гол субъектууд болох тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороодын байнгын идэвхитэй үйл ажиллагаа, дотоод хяналтын систем хангалтгүй байгаа нь мэдрэгдсэн;
3. Ихэнх хоршоодын сонгуультнуудын чадамж сул, идэвхи муутай, сонгууль нь өрсөлдөөн багатай явагддаг, үүрэг хариуцлагаас илүүтэйгээр бие биедээ харилцан итгэсэн байдлаар ёстой нөгөө найзан дундаа гэдэг шиг ажилладаг байдал нэлээд түгээмэл байсан.

Энэ мэт үнэлгээ хийгдсэн хоршоо болгон дээр тодорхой хэмжээний дутагдал байсанд үнэлгээчид газар дээр нь зөвөлгөө өгч ажилласан болно.

Өнгөрсөн онд өгсөн зөвөлгөө, хийсэн сургалтуудын үр дүнд энэ оны үнэлгээгээр авах оноо ахиж байвал манай үнэлгээ, сургалтын ач холбогдол гарах учиртай байв.

Энэ онд орон нутгийн бүх хоршоод, Улаанбаатарын хоршоодын 80 орчим хувь нь хоёрдох үнэлгээнд хамрагдлаа.

Энэ онд хоёрдох удаагийн үнэлгээ хийгдсэн хоршооны авч байгаа үнэлгээний оноо ерөнхийдөө ямар нэгэн хэмжээгээр өсч гарч байна.

Энд ганц хоёрхон жишээ хэлбэл:

Хөвсгөл аймгийн 3 хоршооны авсан оноо 12,7-32,3, Сэлэнгийн 2 хоршооных 22,4-31,0, Сүхбаатарынх 10,8-16,3, Дорнодын 4 хоршооных 16-29, Дундговийн 6 хоршооных 4,6-32,0, Хэнтийн 3 хоршооных 5-28 пунктээр тус тус өссөн харагдаж байна.

Энэ үнэлгээгээр авсан онооны өсөлтийн хувь хэмжээ бүрийн ард тодорхой ажил нь сайжирч байгаа дүр зураг харагдана гэж бодохоор энэхүү төслийн шугамаар бүх ХЗХ-дыг хамруулан хийсэн үнэлгээ, сургалтын үр дүнд манай ХЗХ-ны системийн үйл ажиллагаа бүхэлдээ урагшилж, дэлхийн жишиг рүү алхам алхамаар ойртож байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

ХЗХ-ны системийн 2014 оны 2-р улирлын түвшинг төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх 2011 онтой харьцуулж үзэхэд үндсэн гол үзүүлэлтүүд нь ихээхэн өссөн харгадаж байгаа нь төслийн үр өгөөж юм.

Энэ хооронд ХЗХ-ны тоо хэдийгээр 23-аар буурсан ч нийт гишүүдийн тоо 2,4 хувиар, активын хэмжээ 24,1 хувиар, гишүүддээ олгосон зээлийн хэмжээ 48,3 хувиар, гишүүдийн хуримтлал 19,9 хувиар, хувь хөрөнгө 20,9 хувиар, хоршоологчдын өмч 46,3 хувиар тус тус өссөнийг төслийн үр өгөөжтэй холбон үзэх бүрэн үндэслэлтэй гэж үзэж байна.

Цаашид манай холбоо энэхүү үнэлгээнийхээ системийг захиалагт үйлчилгээний нэг чухал хэлбэр болгон авч үлдэх бөгөөд системийн тогтвортой хөгжлийг хангах хүчирхэг хэрэгсэл, тухайн хоршооны үйл ажиллагааны түвшинг тодорхойлогч гол хүчин зүйл хэмээн үзэхүйц хэмжээний ач холбогдолтой үнэ цэнэтэй зүйл байлгах болно.

Сайн үнэлгээтэй хоршоо бөөний зээл болон холбооны тогтворжилтын үйлчилгээнд тэргүүн ээлжинд хамрагдах, улсын тэргүүний хоршоонд тодорхойлогдох, хүмүүс нь төр засгийн шагнал урамшуулал хүртэх, улсын чанартай хурал зөвөлгөөн, бусад арга хэмжээнд оролцох давуу эрхийг эдлэх болно.

Хоршооны үнэт зүйлс нь итгэл үнэмшил болон хууль ёсны байр суурийг бий болгоход тусалдаг.

Хууль тогтоох байгуулагаас гаргасан хуулиуд нь асуудлын ерөнхий зохицуулалт, зарчмуудыг тогтоож өгдөг бөгөөд хуулийг хэрхэн хэрэгжүүлэх, мөрдөхтэй холбоотой бүхий л нарийн заалтуудыг тэр бүр агуулдаггүй.

Хууль тогтоомжийг боловсруулах, хянах болон мөрдүүлэх үйл явцыг журмаар зохицуулдаг.

Зохих дүрэм журам байхгүй тохиолдолд сайн хууль гаргасан ч түүнийг амжилттай хэрэгжүүлэх буюу мөрдөх боломжгүй болдог муу талтай.

Ер нь хууль, журам нь өөрөө төгсгөл биш бөгөөд харин илүү хүчирхэг, илүү сайн зүйлсийг бий болгоход чиглэгдсэн арга хэрэгсэл юм.

Бидний өмнө тулгараад байгаа нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудал бол ХЗХ-дыг тогтвортой хөгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Тогтворжилтын сан” байгуулж, тогтворжилтын үйлчилгээний оновчтой, үр өгөөжтэй системийг бий болгох явдал.

Энэ асуудал шийдвэрлэгдэхгүй цаг хугацаа алдсаар байсны гол шалтгаан нь тогтворжилтын сангийн мөнгийг захиран зарцуулах эрх хэмжээ, арга хэрэгсэлийн зөв шийдлийг олж чадахгүй байсантай холбоотой байсныг 10-р сарын эхээр болсон нэгэн хэлэлцүүлгийн үр дүнд ойлгож мэдээд гарцыг нь тодорхойлж чадсанаар одоо энэ ажил шийдвэрлэгдэх шатандаа ороод байгаа.

Энд хэлэхгүй байж болохгүй нэг зүйл бол манай төрийн зохицуулалтын байгууллага маань ХЗХ-ны нийгэм дэх хоёрдох байр суурь нь болсон хоршооны зарчим дээр суурилсан, хараат бус бүтэц гэдэг тал дээр нь сул анхаарч хоршооллын мэргэжлийн байгууллагууд болон хоршооны асуудал эрхэлсэн засгийн газрын байгууллагуудтай нягт хамтран ажиллахгүй, дан ганц бичил санхүүгийн байгууллага гэдэг тал дээр нь хэт анхаарч байгаагаас хоршооны үндсэн зарчим, үнэт зүйлс, бие даасан хараат бус байдал хэрэгжихэд зарим талаар хүндрэл үүсч болзошгүй байна

ХЗХ-ны эрхэм төлөөлөгчидөө. Та бид нар “Та энд амьдардаг, таны мөнгө ч энд байх ёстой” гэсэн тэнгэрлэг уриаг хөгжлийнхөө үндсэн концепцоо болгоцгооё оо.

Манай улсад арилжааны 12 банк байна. Эдгээрийн 1 нь төрийн, бусад 11 банкны 1-2 нь л үндэсний хөрөнгө оруулалттай банк байна.

Энэ юу хэлж байна гэвэл гадаадын хөрөнгө оруулалттай эдгээр банкууд манай аж ахуйн нэгжүүд, магадгүй танай хоршооны, монгол улсын иргэдийн маань сул чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг өөртөө төвлөрүүлэн аваад эргүүлээд манай улсын иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэлхийн дундаж хүүнээс 2-3 дахин өндөр хүүтэй зээл олгож, их хэмжээний ашиг олоод түүнээ ногдол ашиг хэлбэрээр зүгээр л аваад гарчихаж байна.

Үүнд банк бус санхүүгийн байгууллагууд ч хамаарна.

Тэгвэл ХЗХ-ны мөнгө гагцхүү гишүүддээ очно. Гишүүдэд очсон мөнгө сумандаа, аймагтаа, бүр цаашиллаа гэхэд монгол улс дотроо шингэнэ.

Бага, дунд орлоготой, өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөгүй ихэнх иргэд, жижиг аж ахуйн нэгжүүд банкны зээлийн бүтээгдэхүүнд хамрагдаж чадахгүй байгаа нь нууц биш.

Банкны системийн энэ хатуу зарчимтай манай бичил санхүүгийн байгууллагууд, тэр дундаа ХЗХ-д эвлэрээд суугаад байж таарахгүй.

Банкны зээлд хамагдаж чадахгүй байгаа эдгээр иргэд, аж ахуйн нэгж, хоршоод бол ХЗХ-ны эзэмшвэл зохих зах зээл, зорилтот бүлгүүд юм.

Өөрөөр хэлбэл ХЗХ-д нэвтрэн орох зах зээлийн орон зай хангалттай байна гэсэн үг.

Ийм жижиг аж ахуйн нэгжүүд ХЗХ-д гишүүнээр элсэн орж санхүүгийн хэрэгцээгээ хангуулах, түр зуур илүүдэлтэй байгаа санхүүгийн нөөцөө ХЗХ-д төвлөрүүлэн эх үүсвэрээр дэмжих хамтын ажиллагааг хөгжүүлэхэд манай ХЗХ-д ихээхэн санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.

Хэд хэдэн үйлдвэрлэлийн хоршоодыг түшиглэсэн нэг хэрэглээний хоршоо, мөн нэг ХЗХ гэсэн гурвалсан сүлжээ болгох боломж байгаа юм.

Энэ тохиолдолд үйлдэвэрлэлийн хоршоод өөрийн бүтээгдэхүүнээ шууд хэрэглээний хоршоондоо өгдөг, хэрэглээний хоршоо нь борлуулалтын маркетингийг нь хариуцаж зах зээлтэй харьцдаг, ХЗХ нь энэ хоёр хоршоодын аль алинд нь зээл олгож, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг үйлдвэрлэл, борлуулалт, санхүүгийн цогцолборыг бий болгон хөгжүүлдэг туршлага африкийн хөгжиж байгаа орнуудад гараад байна.

Стратегийн чанартай энэ чухал туршлагыг дэлгэрүүлэхэд бидний идэвхитэй оролцоо хэрэгтэй байна.

ХЗХ-ны хөдөлгөөнийг эрчимжүүлэх, хөгжлийг нь түргэтгэхэд тулгарч байгаа хүндрэл бэршээлийг амжилттай даван туулахад тус дэм болох олон арван санал санаачлага, арга туршлага байгааг бид овжноор олж харж, өөрийн орны онцлогт тохируулан авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүний тулд бүгдээрээ хөдлөх хэрэгтэй.
Хөдөлбөл мөр гарна гэсэн мэргэн үг байдаг
Хөдлөхгүй бол мөр гарахгүй, хөгжих ч үгүй
Хөдлөнө гэдэг нь хөдөлмөрлөхийн нэр,
хөдөлмөрлөсний эцэст хөгжил ирнэ ээ.

Хамтран ажиллаж, хамтдаа хөгжицгөөе

Анхаарал тавьсанд баярлалаа